Монгол улс дахь зоонозын өвчний эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээ

Б.Амгаланбаяр[1,3], О.Нандин-Эрдэнэ[2]

[1]АШУҮИС, НЭМС, Эдидемиологи, биостатистикийн тэнхим
[2]ХАБҮЛЛ, Захиргаа, техник хангамжийн хэлтэс
[3]ЗӨСҮТ, Захиргааны алба
Цахим шуудан: Amgaa9797@gmail.com, Утас: 99100733

Түлхүүр үг:

Зоонозын өвчин
Эрх зүй
Хууль
Тушаал
Журам

Товч утга:

Үндэслэл: Дэлхий дээр хүн, мал амьтдад халдвар үүсгэж болзошгүй 1415 бичил биетнийг нээн илрүүлсэн байдгаас 60 орчим хувь нь зоонозын өвчлөл эзэлдэг. Манай орны газар зүй, байгаль цаг уурын онцлог бүхий нутагтай, зоонозын өвчний бүх төрлийн агуулагч, дамжуулагчидтай байдаг. Хүн амаасаа 20 дахин их бэлчээрийн болон тэжээвэр мал, амьтантай зэрэг үндэслэлүүд нь зоонозын халдварт өвчний өндөр эрсдэл бүхий оронд тооцогддог болохыг НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн байгууллага мэдээлсэн. Зоонозын халдварын хүний өвчлөлийн 2023 оны тохиолдлын тоог сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 13.5 дахин өссөн байна. Үүний 86.4 хувийг хачгаар дамжих халдвар, 10.6 хувийг галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол, тарваган тахал, хумхаа, боом, бэтгийн хүний өвчлөл тус тус эзэлж байна. Иймд зоонозын халдварын үеийн эрх зүйн баримт бичигт үнэлгээ хийж, цаашдын чиг хандлагыг тодорхойлох шаардлагатай байна. **Зорилго:** Монгол улсын хэмжээнд зонхилон тохиолдож буй зоонозын халдварт өвчний талаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх. **Арга, аргачлал:** Судалгааг дескрептив болон чанарын судалгааны баримт бичиг судлах контент анализын аргыг ашиглан зоонозын халдварт өвчний бүтэц, зохион байгуулалт, тусламж, үйлчилгээ, тандалтын тогтолцоо, хариу арга хэмжээтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг судалсан. Судалгаанд нийт 9 төрлийн 96 эрх зүйн баримт бичгүүдийг цуглуулан docs.google.com программын spreadsheets цэсэд эрх зүйн баримт бичгүүдийг төрөлжүүлэн ангилж, эрх зүйн орчны чиг хандлага, давхцалыг илрүүлэх, шинж чанарыг тодорхойлох, хэрэгжилт, хоорондын уялдаа холбоог баримт бичгийн болон агуулгын задлан шинжилгээний аргаар судалгааг хийж үр дүнг боловсруулсан. **Үр дүн:** Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005), ДЭМБ-ын Ази номхон далайн бүсийн гишүүн орны хувьд Ази номхон далайн бүсийн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, шинэ сэргэн тархах халдварт өвчний стратеги (APSED III) 8 чиглэлийн бүрэн болон хэсэгчлэн хэрэгжүүлдэг ч 2017 оноос хойш “Зоонозын өвчин” гэсэн IV бүлгийг нэмж оруулан гишүүн орнуудын хамт хэрэгжүүлж байна. Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 3 зүйл, заалтыг дам хэлбэрээр, Дархлаажуулалтын тухай хуулийн 9 заалтыг шууд, 2024 онд шинээр батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг Зоонозын халдварт өвчний үеийн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд зохион байгуулах, өвчлөл, дэгдэлт, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тохиолдолд хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах үйл хүрээнд бүхэлд нь тус тус мөрддөг нь бусад төрийн байгууллагуудын нийтлэг мөрдөж буй хууль эрх зүйн хүрээнд байгаа ч Эрүүл мэндийн яамны харьяа тусгай мэргэжлийн төвийн хувьд тусгайлсан хууль болон шууд хэрэгжүүлэн ажиллах заалтууд тодорхой тусгагдаагүй байна. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160 дугаар тушаалыг мөрдөн тарваган тахал, боом, хачигт халдварууд, галзуу, бэтэг зэрэг зонхилон тохиолдох 6 өвчний хяналт сэргийлэлтийн зааврыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа ч нийт судалж, шинжилж, хяналтад авах шаардлагатай 34 зоонозын халдвараас 6 (17.6%) халдварыг батлагдсан зааврын дагуу хянаж байна. **Дүгнэлт:** Зоонозын өвчний тусламж, үйлчилгээтэй холбоотой болон бусад салбаруудтай хамтран ажиллах, хяналт, тандалтын тогтолцооны эрх зүйн орчны хамрах хүрээ дутагдалтай байна. Эрүүл мэндийн салбарын хүрээнд хэрэгжүүлэхээр батлагдсан зоонозын халдварын хяналт, тандалт, хариу арга хэмжээтэй холбоотой тушаал, журам зааврын тоо нэмэгдэхэд дагаад хүний өвчлөлийн тохиолдлын тоо буурсан байна.

Үндэслэл: Дэлхий дээр хүн, мал амьтдад халдвар үүсгэж болзошгүй 1415 бичил биетнийг нээн илрүүлсэн байдгаас 60 орчим хувь нь зоонозын буюу зэрлэг, гэрийн тэжээвэр амьтад, шумуул, хачиг зэрэг дамжуулагчдаас хүнд, хүнээс хүнд халдварладаг зоонозын өвчлөл эзэлдэг. Манай орны газар зүй, байгаль цаг уурын онцлог бүхий нутагтай, зоонозын өвчний бүх төрлийн агуулагч, дамжуулагчидтай, хүн амын 15 хувь орчим нь малчид буюу өдөр тутам бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг, хүн амаасаа 20 дахин их бэлчээрийн болон тэжээвэр мал, амьтантай зэрэг үндэслэлүүд нь зоонозын халдварт өвчний өндөр эрсдэл бүхий оронд тооцогддог болохыг НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн байгууллага мэдээлсэн. 2013 оноос хумхаагийн өвчний 13 тохиолдол зөөвөрлөгдөн бүртгэгдсэн нь хил дамжин тархах эрсдэл нэмэгдсээр байна. Сүүлийн жилүүдэд зоонозын шалтгаант халдваруудын төрөл, өвчлөлийн тохиолдол нэмэгдэж байна. Тухайлбал 2023 оны тохиолдлын тоог сүүлийн 10 жилийн дундажтай харьцуулахад 13.5 дахин өссөн байна. Үүний 86.4 хувийг хачгаар дамжих халдвар, 10.6 хувийг галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдол, тарваган тахал, хумхаа, боом, бэтгийн хүний өвчлөл тус тус эзэлж байна. Иймд зоонозын халдварын үеийн эрх зүйн баримт бичигт үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх бодлогыг тодоорхойлох шаардлагатай байна.

Зорилго: Монгол улсын хэмжээнд зонхилон тохиолдож буй зоонозын халдварт өвчний талаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх

Арга, аргачлал: Судалгааг дескрептив болон чанарын судалгааны баримт бичиг судлах контент анализын аргыг ашиглан зоонозын халдварт өвчний тусламж, үйлчилгээний үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн орчныг судалсан.

Мэдээлэл цуглуулах: Зоонозын өвчин судлалын үндэсний төв, 14 аймгийн зоонозын өвчин судлалын төвүүдийн хэмжээнд зоонозын халдварт өвчний тусламж, үйлчилгээ, удирдлага бүтэц зохион байгуулалттай холбоотой 10 төрлийн 31 үйл ажиллагааны хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ДЭМБ-аас батлан гаргасан олон улсын удирдамж, гарын авлага, дүрэм, Монгол улсын хуулийн холбогдох зүйл, заалтууд, УИХ, МУЗГ-ын тогтоол, Эрүүл мэндийн сайдын болон ЗӨСҮТ-ийн захирлаар тушаалаар батлуулсан журам, заавар зэрэг баримт бичгүүдийг цахим мэдээллийн сайт болон архивын нэгж материалаас цуглуулсан.

Ёс зүйн зөвшөөрөл: НЭМС-ийн Эрдмийн зөвлөлийн 2019 оны 01 сарын 15-ны өдрийн хурлаар судалгааны сэдэв, арга аргачлалыг батлуулж (№19/15), АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2019 оны 01 сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрээр судалгааны ажлыг эхлүүлэх ёс зүйн зөвшөөрөл (№2019/3-01) авч, судалгааг эхлүүлсэн.

Статистик боловсруулалт: Зоонозын халдварт өвчний бүтэц, зохион байгуулалт, тусламж, үйлчилгээ, тандалтын тогтолцоо, хариу арга хэмжээтэй холбоотой 9 төрлийн 96 эрх зүйн баримт бичгүүдийг цуглуулан docs.google.com, spreadsheets программд оруулан эрх зүйн баримт бичгүүдийг төрөлжүүлэн ангилж, эрх зүйн орчны чиг хандлага, давхцалыг илрүүлэх, шинж чанарыг тодорхойлох, хэрэгжилт, хоорондын уялдаа холбоог баримт бичгийн болон агуулгын задлан шинжилгээний аргаар судалгааг хийж үр дүнг боловсруулсан.

1. Олон улсад мөрдөгдөж буй – 3 (ОУЭМД-1, Гарын авлага 1, Стратеги 1)
2. Монгол улсын хууль – 8 (Хуулийн холбогдох зүйл, заалтууд болон бүхэлд нь)
3. Монгол Улсын Их Хурлын тогтоол – 3
4. Монгол Улсын Засгийн Газрын тогтоол – 5
5. Монгол Улсын Шадар сайдын тушаал – 1
6. Хамтарсан тушаал – 2
7. Эрүүл мэндийн сайдын тушаал – 21
8. ЗӨСҮТ-ийн захирлын тушаал – 47
9. Стандарт – 6

Үр дүн: Зоонозын салбарын тандалтын үндсэн үйл ажиллагаа нь байгалийн голомт бүхий зоонозын халдварт өвчнүүдийг зэрлэг, тэжээвэр, мэрэгч амьтад, дамжуулагчдад чиглэсэн тандалт судалгааг хийж, илрүүлэх, хүн амыг халдвараас урьдчилан сэргийлэх, хянах, дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, мэдээлэн эрсдэлийг хязгаарлах зорилготойгоор холбогдох эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд үйл ажиллагааг зохион байгуулдаг. Одоогийн санхүүжилт, хүний нөөц, техник тоног төхөөрөмжийн хүчин чадлаар жилд дундажаар 17.100 мк^2 талбайд буюу Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 1.14%-д нь зоонозын халдварын байгалийн голомтын тандалт судалгааг хийж гүйцэтгэж байна.

Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005), Ази номхон далайн бүсийн гишүүн орны хувьд Ази номхон далайн бүсийн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, шинэ сэргэн тархах халдварт өвчний стратеги (APSED III)-ын 8 чиглэлээр бүрэн болон хэсэгчлэн хэрэгжүүлдэг бөгөөд 2017 оноос хойш бүсийн болон олон улсын түвшинд хамтын ажиллагаа, хариу арга хэмжээ шаардлагатай байгаа “Зоонозын өвчин” гэсэн IV бүлгийг нэмж оруулан бие даасан хэлбэрээр тус тус хэрэгжүүлж байгаа нь олон улсын түвшинд зоонозын халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, нөөц, бэлэн байдлыг хангах асуудлууд нь нэн тэргүүнд тавигдаж байгаа нь харагдаж байна.

“Эрүүл мэндийн тухай хууль”-ийг зоонозын халдварт өвчний тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай мэргэжлийн төв статус бүхий эрүүл мэндийн байгууллагын хувьд бүхэлд нь баримтлан ажиллаж байгаа ч 3 зүйлийн 5 заалтыг олон улсын хөл, хориот өвчний хариу арга хэмжээ, голомтод ажиллахад шууд хэлбэрээр хэрэгжүүлдэг байна. Эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлэхээс гадна зоонозын шалтгаанаар үүссэн нөхцөл байдлыг цар хүрээгээр нь авч үзэж, гамшиг гэж тодорхойлсон тохиолдолд “Гамшгийн тухай хууль”-ийг баримтлан тохиолдлын удирдлагын тогтолцооны горимоор өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин бусад салбаруудтай хамтран хорио цээрийн дэглэм тогтоох, голомтын бүсийг цомхотгох, шуурхай

хариу арга хэмжээг зохион байгуулахад үйл ажиллагаа нь чиглэгддэг байна. Мөн “Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль”-ийн 3 заалтыг дам хэлбэрээр, зоонозын халдварт өвчний дархлаажуулалтыг зохион байгуулах чиглэлээр “Дархлаажуулалтын тухай хууль”-ийн 9 заалтыг шууд, зоонозын халдварт өвчний үүсгэгчийн өсгөвөр омгийг, хамгаалах, хадгалах, гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн салбарын нөөцийн бэлэн байдлыг хадгалах хамгаалах нууцлах биотерроризм болон болзошгүй халдлагаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой “Төрийн болон албаны нууцын тухай хууль”-ийн 3 зүйлийн 6 заалтыг мөрдлөг болгон шууд, 2024 онд шинээр батлагдсан “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль”-ийг зоонозын халдварт өвчний үеийн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд зохион байгуулах, өвчлөл, дэгдэлт, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тохиолдолд хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд бүхэлд нь тус тус мөрддөг нь бусад төрийн байгууллагуудын нийтлэг мөрдөж буй хууль эрх зүйн хүрээнд байгаа ч Эрүүл мэндийн яамны харьяа тусгай мэргэжлийн төвийн хувьд тусгайлсан хууль болон шууд хэрэгжүүлэн ажиллах заалтууд тодорхой тусгагдаагүй байна.

Монгол улсын хувьд Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160 дугаар тушаалыг мөрдөн тарваган тахал, боом, хачигт халдварууд, галзуу, бэтэг зэрэг зонхилон тохиолдох 6 өвчний хяналт сэргийлэлтийн зааврыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа ч нийт судалж, шинжилж, бүртгэж буй 34 зоонозын халдвараас 6 (17.6%) халдварыг батлагдсан зааврын дагуу хянаж байна. Үүнээс удирдлага, зохион байгуулалт, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдал, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, зоонозын халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалтай холбоотой эрх зүйн бичиг баримтууд хангалттай байгаа бол лабораторийн оношзүйн тусламж, үйлчилгээ, био үйлдвэрлэл, ариутгал, халдваргүйтгэл, чанарын хяналт, био аюулгүй байдал, зоонозын халдварт өвчний сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, мэдээлэл технологийн чиглэлийн эрх зүйн бичиг баримтууд хангалтгүй байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Зоонозын өвчний тусламж, үйлчилгээ үзүүлэх болон бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчны бүрдэл

Үйл ажиллагааны чиглэл	Хууль эрхзүйн орчин бүрдсэн эсэх						
	Олон улсын түвшинд мөрдөх эрх зүйн баримт бичиг	Хууль	УИХ-ын тогтоол	Засгийн газрын тогтоол	Эрүүл мэндийн сайдын тушаал, журам, заавар	Захирлын тушаал, журам	Стандарт
Удирдлага, зохион байгуулалт, бодлогын хэрэгжилтийг зохицуулах		+	+	+	+	+	+
Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	+	+				+	+
Лабораторийн оношзүйн тусламж, үйлчилгээ	+				+	+	+
Зоонозын халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал	+	+			+	+	
Био үйлдвэрлэл			+			+	+
Ариутгал, халдваргүйтгэл					+	+	+
Хууль бусаар агнаж, хураагдсан амьтдын биологийн төрөл зүйл, зоонозын халдварын эрсдэлийг тогтоох						+	
Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдал	+	+	+		+	+	
Чанарын хяналт, био аюулгүй байдал					+	+	
Зоонозын халдварт өвчний сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, мэдээлэл технологи		+			+	+	

2013 оноос хойш зоонозын халдварын тусламж, үйлчилгээ, бүтэц зохион байгуулалттай холбоотой тушаал, журмыг эрүүл мэндийн сайдын болон төвийн захирлын нийт 74 тушаал, журам, заавар батлуулан ажиллаж байгаагаас 21 (28.4%) нь эрүүл мэндийн сайдын тушаал, 6 (8.1%) нь стандарт, 47 (63.5%) нь дотоотдоо баталж мөрдөн ажиллаж байна. Хариу арга хэмжээний тушаал зааврын тоо нэмэгдэхэд хүний өвчлөлийн тохиолдлын тоо буурсан дүнтэй байна (Зураг 1).



Зураг 1. 2013-2023 онд бүртгэгдсэн зоонозын халдварт өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг харьцуулсан дүн

Хэлцэмж: Энэхүү судалгаа нь зоонозын өвчний чиглэлээр эрх зүйн орчинд хийсэн Монгол улс дахь анхны судалгаа юм. Бидний судалгаа нь зоонозын салбарын хүрээнд дам болон шууд хэрэгжүүлэхээр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 96 эрх зүйн баримт бичгийг цуглуулан мэдээллийн жагсаалт үүсгэн дүн шинжилгээг хийсэн. Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005), Ази номхон далайн бүсийн гишүүн орны хувьд Ази номхон далайн бүсийн нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, шинэ сэргэн тархах халдварт өвчний стратеги (APSED III)-ын 8 чиглэлээр бүрэн болон хэсэгчлэн хэрэгжүүлдэг. Хууль эрх зүйн хэсэгт баримт бичгийн агуулгын шинжилгээ хийж, үр дүнг боловсруулахад ихэвчлэн удирдлага, бүтэц, зохион байгуулалттай холбоотой заалтууд байна. Зоонозын өвчний тусламж, үйлчилгээтэй холбоотой эрх зүй нь салбарын сайдын болон төвийн захирлаар баталгааждаг байна. 2013 оноос хойш зоонозын халдварын тусламж, үйлчилгээтэй холбоотой тушаал, журмыг эрүүл мэндийн сайдын болон төвийн захирлын нийт 74 тушаал, журам, заавар батлуулан ажиллаж байгаагаас 21 (28.4%) нь эрүүл мэндийн сайдын тушаал, 6 (8.1%) нь стандарт, 47 (63.5%) нь дотоотдоо баталж мөрдөн ажиллаж байна. Хариу арга хэмжээний тушаал зааврын тоо нэмэгдэхэд хүний өвчлөлийн тохиолдлын тоо буурсан дүнтэй байна.

2015 онд ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр салбар дундын хамтын ажиллагааны шинжээчдийн багийн хийсэн "Эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ бэлэн байдлыг үнэлэх хамтарсан үнэлгээ"-ээр зоонозын халдварт өвчний үед мөрдөж буй Эрүүл мэндийн сайдын тушаал журмыг шинэчлэх[2], 2022 онд ДЭМБ, ДАЭМБ, Дэлхийн Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас зохион байгуулсан "Салбар хоорондын хамтын ажиллагааны 3 талт олон улсын үнэлгээ"-ээр "Нэг эрүүл мэнд" үзэл баримтлалд тулгуурлан байгаль орчин, хүнс хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарууд хамтын ажиллагааг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжүүлэх[4], 2023 онд ДЭМБ болон олон улсын шинжээчдийн хамтарсан багийн "Монгол Улсад Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-ийг хэрэгжүүлэх суурь чадавхын хөндлөнгийн хамтарсан үнэлгээ"-ээр Монгол улсад зоонозын халдварт өвчний хяналт, тандалтыг өргөжүүлэх, хамтарсан тандалт судалгаа ялангуа зэрлэг амьтдын дундах тандалт судалгаа хийх эрх зүйн орчныг салбар хоорондын түвшинд бүрдүүлж ажиллах шаардлагатай[12] зэрэг үр дүнгүүд нь бидний судалгааны үр дүнтэй нийцэж байна.

БНХАУ-д хийсэн судалгаагаар зоонозын халдварт өвчний хяналт, тандалтыг сайжруулах үйл ажиллагааг тус улсын Эрүүгийн тухай хууль, Зэрлэг амьтдыг хамгаалах тухай хууль, Захиргааны тусгай зөвшөөрлын тухай хууль, Байгаль орчин, экологи, хөгжил шинэчлэл, ёс заншил зэрэг нэмэлт хууль тогтоомжуудад тодорхой заасан ч одоогийн байгаа дутагдалтай талуудыг арилгах, нэгдсэн зохицуулалттай, олон салбарын үйл ажиллагаг хамарсан хяналт, тандалтын тусгайлсан систем шаардлагатай, хууль эрх зүй орчин нь зоонозын өвчний эрсдэлийг хянах, бууруулахад баримтлах бодлоготой уялдан хэрэгжих зохицуулалтын хэрэгжих байдал бэрхшээлтэй байгаа зэрэг үр дүнгүүдийг онцолсон байна.[13] Энэ нь бидний судалгааны үр дүнтэй ижил байгаа нь ажиглагдлаа. Цаашид дэлхий дахинд зоонозын халдврт өвчнийг хянах, тандах тогтолцоонд олон салбар хоорондын хамтын ажиллагаанд суурилсан эрх зүйн зохицуулалтыг улс, бүс нутгийн хэмжээнд бий болгож, хэрэгжүүлэх шаардлагатай байгаа талаар олон улсын судалгаануудад дурьдагдсан байна.

Дүгнэлт: Зоонозын өвчний тусламж, үйлчилгээтэй холбоотой болон бусад салбаруудтай хамтран ажиллах, хяналт, тандалтын тогтолцооны эрх зүйн орчны хамрах хүрээ дутагдалтай байна. Эрүүл мэндийн салбарын хүрээнд хэрэгжүүлэхээр батлагдсан зоонозын халдварын хяналт, тандалт, хариу арга хэмжээтэй холбоотой тушаал, журам зааврын тоо нэмэгдэхэд дагаад хүний өвчлөлийн тохиолдлын тоо буурсан байна.

Талархал: Уг судалгааны ажлыг дэмжин, анхдагч болон хоёрдогч мэдээллээр хангаж, судалгаа хийх орчныг бүрдүүлсэн Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн хамт олон, судалгаа хийхэд туслалцаа үзүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн хамт олондоо талархсанаа илэрхийлж байна.

Ном зүй:

1. *https://iris.who.int/bitstream/handle/10665/325620/9789241514934-eng.pdf?sequence=1 (2024.03.10)*
2. *Эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ бэлэн байдлыг үнэлэх хамтарсан үнэлгээний тайлан, 2015, х.4-7*
3. *https://www.oie.int/wahis2/public/wahid.php/Countryinfo/Zoonoses (2023.10.05)*
4. *"National Bridging Workshop One Health Roadmap for Mongolia" 2023, х.2-8*
5. *https://iris.who.int/bitstream/handle/10665/357087/9789240051980-eng.pdf?sequence=1 (2023.05.10)*
6. *Статистик мэдээллийн нэгдсэн сан, "Монгол улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын хандлага, хэтийн төлөв", 2020 он (2024.01.17)*
7. *Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн үйл ажиллагааны тайлан, Улаанбаатар, 2013-2023 он*
8. *Зоонозын өвчин судлалын үндэсний төв, "Статистик эргэн мэдээлэл", Улаанбаатар, 2022 он х.10-15 (2024.02.18)*
9. *World Health Organization, "General Guidelines for Methodologies on Research and Evaluation of Traditional Medicine", 2016 он (2024.02.17)*
10. *World Health Organization, "Evaluation Practice Handbook", 2015 он (2024.03.15)*
11. *Prolific Authors in the "Journal of Agricultural Education": A Review of the Eighties, 36 (1): p 55-63, Aug 1995,*
12. *"Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-ийг хэрэгжүүлэх суурь чадавхын хөндлөнгийн хамтарсан үнэлгээ"-ний тайлан P.5 Zoonosis х.15, 18-19, 2023*
13. *Hongying, Li,a,d Yufei, Chen,b, Catherine, Machalaba,a Hao, Tang,c, Aleksei, A. Chmura, Mark D, Fielder, and Peter Daszaka, Wild animal and zoonotic disease risk management and regulation in China: Examining gaps and One Health opportunities in scope, mandates, and monitoring systems 370 (2): 21 Dec 2021, pp. 10.1016*

Analysis of the legal framework of zoonotic diseases in Mongolia

Amgalanbayar B[1,3], Nandin-Erdene O[2]

[1]Department of Epidemiology and Biostatistics, School of public health, MNUMS
[2]Department of administration and hardware, NRLFS
[3]Department of administration, NCZD
E-mail: Amgaa9797@gmail.com, Tel: +976-99100733

Background: A total of 1415 micro organisms that can cause infection in humans and animals have been discovered in the world, and about 60% are zoonotic diseases. Our country has geographical, natural and climatic features, and has all kinds of carriers and transmitters of zoonotic diseases. The Food and Agriculture Organization of the United Nations has reported that countries with 20 times more livestock and livestock than their population are considered countries with a high risk of zoonotic diseases. The number of human cases of zoonotic infections in 2023 has increased by 13.5 times compared to the average of the last 10 years. Of this, 86.4 percent were tick-borne infections, 10.6 percent were cases of rabies, marsupial plague, malaria, anthrax, and herpes. Therefore, it is necessary to evaluate the legal documents in the period of zoonotic infections and determine future trends.

Aim: Analyzing the current legal framework for zoonotic infectious diseases prevalent throughout Mongolia.

Materials and Methods: The research was conducted using descriptive and qualitative research Content-analysis methods to examine legal documents related to the structure, organization, care, services, surveillance system, and response to zoonotic infectious diseases. In the study, a total of 96 legal documents of 9 types were collected and entered into docs. google.com, spreadsheets and the documents were classified by variety, trends and coincidences in the legal environment were identified, characteristics were determined, and the relationship between them was studied. The research was conducted by document and Content-analysis methods, including the evaluation of the implementation status, and the results were developed.

Results: The International Health Regulations (2005) and Asia-Pacific Member States of the WHO Asia-Pacific Region fully and partially implement the 8-pronged Asia-Pacific Strategy for Public Health and Emerging Diseases (APSED III), 2017 Since 2010, Chapter IV "Zoonotic Diseases" has been added and is being implemented together with the member states. 3 articles and provisions of the Law on Animal Health are indirect, 9 provisions of the Law on Immunization are directly, and the Law on Public Health Care and Services, newly approved in 2024, to organize public health care and services during zoonotic infectious diseases, diseases and outbreaks at the national level, in the event of a serious public health emergency, response measures are implemented as a whole within the framework of the legal framework commonly followed by other government institutions, but for the special professional center under the Ministry of Health, there are specific laws and provisions for direct implementation. not reflected. 2017 Order No. A/160 of the Minister of Health is being investigated and control instructions for 6 common diseases such as bubonic plague, anthrax, tick-borne diseases, and rabies are being investigated in our daily activities, but out of 34 zoonotic infections that need to be fully studied, analyzed, and controlled 6 (17.6%) are monitored by approved guidelines, which is deficient.

Conclusion: There are insufficient legal documents in the field of laboratory diagnostic assistance and services for zoonotic diseases, bioproduction, sterilization, disinfection, quality control, biosafety, training, research, research, and information technology. As the number of regulations and instructions increased, the number of human disease cases decreased.

Keywords: Zoonotic disease, Law, Order, Regulation